



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 670

танай _____-ны № _____-т

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА
Ч.ЭЛБЭГСАЙХАН ТАНАА

Нийслэлийн Багануур үйлдвэрлэл
технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг
хүргүүлж байна.

Хавсралт: 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030787

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2022/09/ НА-СА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn
Улаанбаатар хот 2022 он	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Долгорсүрэн Утас: 325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn Аудитор: Ш.Мөнхжаргал Утас: 325093 Цахим хаяг: munkhjargalsh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НТАГ-2022/09/ НА-СА-ОНА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 671
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 11 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

0020220525

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан	10
4.3 10	
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгө	6,569,300.00	6,966,600.00
35	Бараа материал	6,569,300.00	6,966,600.00
354	Хангамжийн материал	6,569,300.00	6,966,600.00
35410	Бичиг хэргийн материал	858,400.00	1,277,500.00
35420	Бусад хангамжийн материал	3,952,500.00	3,952,500.00
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,569,300.00	6,966,600.00
39	Эргэлтийн бус хөрөнгө	77,422,031,123.56	77,408,073,146.84
39	Үндсэн хөрөнгө	77,422,031,123.56	77,408,073,146.84
393	Биет бус хөрөнгө	77,260,153,741.87	77,255,731,741.76
3	Нийт хөрөнгийн дүн	77,428,600,423.56	77,415,039,746.84
4	Өр төлбөрийн нийт дүн	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	77,428,600,423.56	77,415,039,746.84
512	Хуримтлагдсан үр дүн	182,200,423.56	168,639,746.84
51210	Өмнөх үеийн үр дүн	204,123,229.52	182,200,423.56
51220	Тайлант үеийн үр дүн	-21,922,805.96	-13,560,676.72
6	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	77,428,600,423.56	77,415,039,746.84

2.2 Аудит орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	292,744,100.00	229,419,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,744,100.00	229,419,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	292,744,100.00	229,419,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,693,100.00	292,744,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	314,666,905.96	242,979,876.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,666,905.96	242,979,876.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	281,356,609.20	235,429,901.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,699,422.24	161,384,153.96
210101	Үндсэн цалин	174,699,422.24	95,249,989.02
	Нэмэгдэл		66,134,164.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,391,490.50	19,601,088.26
210201	Тэтгэврийн даатгал	18,204,287.91	17,232,474.11
210205	Эрүүл мэндийн даатгал	2,187,202.59	2,368,614.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,631,000.00	27,341,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,175,600.00	2,886,400.00
210304	Байрны түрээс	24,455,400.00	24,455,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,575,903.50	11,600,682.37
210401	Бичиг хэрэг	3,425,300.00	2,614,200.00

**Багануур Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	4,620,000.00	4,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,799,770.50	2,799,982.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,833.00	1,566,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,800,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,350,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,014,585.00	194,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,885,385.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	129,200.00	194,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,244,207.96	13,957,976.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,704,207.96	13,957,976.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,310,296.76	7,549,975.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,750,000.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,750,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,560,296.76	7,049,975.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,560,296.76	7,049,975.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-21,922,805.96	-13,560,676.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-21,922,805.96	-13,560,676.72

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл			204,123,229.5	204,123,229.5
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	77,246,400,000.0			77,246,400,000.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C07	Тайлант үеийн үр дүн			-21,922,805.96	-21,922,805.96
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	77,246,400,000.0		182,200,423.56	77,428,600,423.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				

D08	Тайлант үеийн үр дүн			-13,560,676.72	-13,560,676.72
D09	2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	77,246,400,000.0		168,639,746.84	77,415,039,746.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	292,744,100.00	229,419,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,744,100.00	229,419,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	292,744,100.00	229,419,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	292,744,100.00	229,419,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	283,256,500.00	229,419,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,256,500.00	229,419,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,946,203.24	221,869,224.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,211,822.24	161,005,809.93
210101	Үндсэн цалин	125,390,509.24	122,999,954.18
210102	Нэмэгдэл	25,693,113.00	25,665,855.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,128,200.00	12,340,000.00
210104	Урамшуулал	9,487,600.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,391,490.50	19,979,432.29
210201	Тэтгэврийн даатгал	13,658,991.47	14,293,394.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,659,000.00	1,810,057.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,306,899.03	1,271,903.79
210204	Ажилгүйдлийн даатгал	348,900.00	265,204.46
210205	Эрүүл мэндийн даатгал	3,417,700.00	2,338,872.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,631,000.00	27,341,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,175,600.00	2,886,400.00
210304	Байрны түрээс	24,455,400.00	24,455,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,159,770.50	10,997,982.37
210401	Бичиг хэрэг	3,240,000.00	3,078,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,620,000.00	4,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,799,770.50	2,799,982.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,350,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,212,120.00	194,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,082,920.00	

Багануур Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,800.00	69,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	59,400.00	125,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,310,296.76	7,549,975.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,750,000.00	500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,750,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,560,296.76	7,049,975.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,560,296.76	7,049,975.41

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2021 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	229,419,200.0	222,369,224.59	7,049,975.41	96.9
2	Нийт зардал	229,419,200.0	222,369,224.59	7,049,975.41	96.9
3	Урсгал зардал	229,419,200.0	222,369,224.59	7,049,975.41	96.9
4	Бараа үйлчилгээний зардал	228,919,200.0	221,869,224.59	7,049,975.41	96.9
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,640,400.0	161,005,809.93	4,634,590.07	97.2
	Үндсэн цалин	123,000,000.0	122,999,954.18	45.82	100
	Нэмэгдэл	25,700,400.0	25,665,855.75	34,544.25	99.8
	Унаа хоолны хөнгөлөлт	16,940,000.0	12,340,000.0	4,600,000.0	72.8
	Ажил олгогчоос НДШ	22,361,400.0	19,979,432.3	2,381,967.71	89.3
	Тэтгэврийн даатгал	15,735,800.0	14,293,394.65	1,442,405.35	90.8
	Тэтгэмжийн даатгал	1,66,400.0	1,810,057.13	-153,657.13	109.2
	ҮОМШӨ-ний даатгал	1,325,100.0	1,271,903.79	53,196.21	95.9
	Ажилгүйдлийн даатгал	331,300.0	265,204.46	66,095.54	80.05
	Эрүүл мэндийн даатгал	3,312,800.0	2,338,872.26	973,927.74	70.6
	Байр ашиглалттай тогтмол зардал	27,341,400.0	27,341,400.0	-	100
	Гэрэл, цахилгаан	2,886,400.0	2,886,400.0	-	100
	Байрны түрээс	24,455,000.0	24,455,000.0	-	100
	Хангамж, баараа материалын зардал	12,348,000.0	12,34,982.37	17.63	100
	Бичиг хэрэг	3,078,000.0	3,078,000.0	-	100
	Шатахуун	4,620,000.0	4,620,000.0	-	100
	Шуудан холбоо	2,800,000.0	2,800,000.0	-	100
	Албан томилот	1,350,000.0	1,350,000.0	-	100
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	500,000.0	500,000.0	-	100
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	228,000.0	194,600.0	33,400.0	85.35
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.0	1,000,000.0	8,800.0	100
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500,000.0	500,000.0	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	229,419,200.0	222,369,224.59	7,049,975.41	96.9
	Орон нутгийн төсвөөс	229,419,200.0	222,369,224.59	7,049,975.41	96.9
	Мөнгөний эхний үлдэгдэл	-	-	-	
	Мөнгөний эхний үлдэгдэл	-	-	-	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэл-нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, шинжлэх ухааны судалгаа, туршилт явуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй өндөр технологи нутагшуулах”-д оршино.

Үйл ажиллагааны чиг үүргийг “Нийгэм эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ыг НИТХ-ын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 122 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,

- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ууд,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар гаргаж ирүүлснийг аудитын явцад аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн батлагдсан маягтаар тайлагнуулж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	6,569.3	6,966.6	397.3
Үндсэн хөрөнгө	77,422,031.1	77,408,073.1	-13,958.0
Нийт хөрөнгө	77,428,600.4	77,415,039.7	-13,560.7
Засгийн газрын хувь оролцоо	77,246,400.0	77,246,400.0	0
Хуримтлагдсан ашиг/+/, алдагдал/-/	182,200.4	168,639.7	-13,560.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	77,428,600.4	77,415,039.7	-13,560.7

Бараа материалын дансны үлдэгдэл 6,966.6 мянган төгрөг болж 397.3 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал худалдан авч зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 77,415,039.7 мянган төгрөг болж 13,958.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан үйл ажиллагаа явуулсан бөгөөд гүйцэтгэлээр 229,419.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 222,369.2 мянган төгрөгийн зардал гарган, 7,049.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн аудитор Ш.Мөнхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ -ын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант жилийн хугацаанд дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас 2.0 хувиар буюу 6,293.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 5,034.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроосон 20 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5. “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.”, 6 дугаар зүйлийн 6.1. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.” 6 дугаар зүйлийн 6.4. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан асуудал нь холбогдох хууль, тогтоомжийн заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар тус байгууллагын дарга, нягтлан бодогч, албан хаагчид ковидын халдвар илэрсэн тул завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,692.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 407.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,285.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	407.4	1	407.4	100
Зөвлөмж	3	5,285.2	3	4,172.6	100.0
Нийт дүн	3	5,692.6	3	5,692.6	100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахалтай холбоотой хөрөнгийн үлдэгдэлд биет тестийн горимыг хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/						
				Акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал										
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроож мэдээлсэн 20 мэдээлэл байна							-	1	
	ДҮН								1	